

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/6/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Мөнхжин  
Утас: 261740 Цахим хаяг: [munkhjind@audit.gov.mn](mailto:munkhjind@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

2024. 04. 25 № 1136  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Гадаад харилцааны сайдын санаачилгаар 6 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтыг анх удаа зохион байгуулсан байна. Энэхүү арга хэмжээний үеэр хоёр талт уулзалтууд хийж, цаашдын харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Гадаад харилцааны сайд үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,000.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 11,284.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.2 дахин давуулан биелүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гадаад харилцааны сайд дангаар хариуцан хэрэгжүүлэх 48 арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжилт 2020-2023 оны дүнгээр 79.4 хувьтай байна гэж Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар үнэлсэн байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,478,534.1</b>	<b>16,955,798.3</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,792,396.8	6,072,982.5
33	АВЛАГА	4,256,577.3	3,891,585.1
34	УРЬДЧИЛГАА	648,823.5	1,264,607.7
35	БАРАА МАТЕРИАЛ	5,780,736.5	5,726,623.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>528,731,764.2</b>	<b>502,364,864.5</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	528,731,764.2	502,364,864.5
39100	Газар	46,423,501.6	45,966,490.4
39200	Биет хөрөнгө	440,348,602.6	414,861,213.2
39300	Биет бус хөрөнгө	41,959,660.0	41,537,160.9
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>547,210,298.3</b>	<b>519,320,662.8</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,101,441.6</b>	<b>1,888,089.3</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,101,441.6	1,245,484.2
41300	Өглөг	1,101,441.6	1,219,865.4
41400	Урьдчилж орсон орлого	-	25,618.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	642,605.2
42200	Урт хугацаат зээл	-	642,605.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>546,108,856.7</b>	<b>517,432,573.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	546,108,856.7	517,432,573.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	208,458,183.0	208,458,183.0
51200	Хуримтлагдсан үр дүн	(89,439,520.1)	(101,884,316.1)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	262,140,844.7	260,991,667.5
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	164,949,349.1	149,867,039.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>547,210,298.3</b>	<b>519,320,662.8</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>126,076,343.6</b>	<b>182,229,747.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,890,285.6	19,179,344.1
120	Нийтлэг татварын бус орлого	12,890,285.6	19,179,344.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,186,058.0	163,050,403.7
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>130,768,481.6</b>	<b>197,928,321.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,768,481.6	197,928,321.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,125,520.5	143,980,064.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,847,453.0	46,392,654.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,268,955.3	1,498,944.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,073,377.9	22,690,020.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,737,133.7	3,131,169.5
2105	Нормативт зардал	29,827.8	23,070.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,336,670.3	1,944,856.6
2107	Томилолт, зочны зардал	6,438,274.6	8,492,183.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,651,960.4	28,662,472.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,741,867.6	31,144,691.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,642,961.1	53,948,257.3
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(4,692,138.1)</b>	<b>(15,698,573.8)</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>544,677.3</b>	<b>142,950.7</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>515,772.3</b>	<b>56,958.0</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(4,663,233.0)</b>	<b>(15,612,581.1)</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	461,330,649.9	-	461,330,649.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	129,691.9	-	129,691.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,460,341.8	-	461,460,341.8
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	86,259,177.6	-	86,259,177.6
7	Өмчид гарсан өөрчлөлт	3,062,570.3	-	3,062,570.3
8	Зарласан ногдол ашиг	(10,000.0)	-	(10,000.0)
9	Тайлант үеийн үр дүн	(4,663,233.0)	-	(4,663,233.0)
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	546,108,856.7	-	546,108,856.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	521,784.5	-	521,784.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	546,630,641.2	-	546,630,641.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,149,177.1)	-	(1,149,177.1)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(12,166,005.4)	-	(12,166,005.4)

17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	(270,304.2)	-	(270,304.2)
19	Тайлант үеийн үр дүн	(15,612,581.1)	-	(15,612,581.1)
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>517,432,573.4</b>	<b>-</b>	<b>517,432,573.4</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>130,708,535.5</b>	<b>189,230,719.0</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,015,130.5	21,241,435.0
120	Нийтлэг татварын бус орлого	16,015,130.5	21,241,435.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	114,693,405.0	167,989,284.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>117,520,119.6</b>	<b>183,917,240.8</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,520,119.6	183,917,240.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,608,950.6	129,700,569.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,522,319.7	48,382,091.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,750,963.3	2,042,879.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,027,088.8	25,357,895.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,511,048.1	4,351,132.1
2105	Нормативт зардал	65,885.3	35,343.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,460,618.1	2,297,237.4
2107	Томилолт, зочны зардал	6,433,264.2	8,474,442.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,912,968.2	26,901,853.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,924,794.9	11,857,693.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,911,169.1	54,216,671.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>13,188,415.9</b>	<b>5,313,478.2</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>240,337.0</b>	<b>265,619.9</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,581,761.1</b>	<b>6,445,059.0</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,581,761.1	6,445,059.0
2200	Дотоод эх үүсвэрээр	11,581,761.1	6,445,059.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(11,341,424.1)</b>	<b>(6,179,439.2)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>411,618.2</b>	<b>(853,453.3)</b>
14	Бусад эх үүсвэр	431,259.8	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	19,641.6	853,453.3
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,258,609.9</b>	<b>(1,719,414.3)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,533,786.9	7,792,396.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,792,396.8	6,072,982.5

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>161,290,052,700.00</b>	<b>115,299,583,778.56</b>	<b>45,990,468,921.44</b>	<b>71.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>161,290,052,700.00</b>	<b>115,299,583,778.56</b>	<b>45,990,468,921.44</b>	<b>71.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>156,202,627,100.00</b>	<b>113,132,623,333.98</b>	<b>43,070,003,766.02</b>	<b>72.4</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>57,183,804,900.00</b>	<b>45,484,284,409.52</b>	<b>11,699,520,490.48</b>	<b>79.5</b>
Үндсэн цалин	54,957,329,100.00	43,420,980,225.78	11,536,348,874.22	79.0
Нэмэгдэл	1,833,038,300.00	1,736,777,204.84	96,261,095.16	94.7
Унаа хоолны хөнгөлөлт	322,020,000.00	277,555,500.00	44,464,500.00	86.2
Урамшуулал	71,417,500.00	48,971,478.90	22,446,021.10	68.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,926,714,800.00</b>	<b>1,407,836,353.02</b>	<b>518,878,446.98</b>	<b>73.1</b>
Тэтгэврийн даатгал	1,727,673,500.00	1,210,157,001.66	517,516,498.34	70.0
Тэтгэмжийн даатгал	49,760,300.00	49,687,255.39	73,044.61	99.9
ҮОМШӨ-ний даатгал	39,808,300.00	39,582,644.32	225,655.68	99.4
Ажилгүйдлийн даатгал	9,952,100.00	9,855,468.33	96,631.67	99.0
Эрүүл мэндийн даатгал	99,520,600.00	98,553,983.32	966,616.68	99.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,386,149,000.00</b>	<b>22,468,471,794.68</b>	<b>5,917,677,205.32</b>	<b>79.2</b>
Гэрэл, цахилгаан	2,035,868,400.00	1,522,115,807.58	513,752,592.42	74.8
Түлш, халаалт	2,200,405,200.00	1,699,242,181.40	501,163,018.60	77.2
Цэвэр, бохир ус	920,899,400.00	662,691,828.26	258,207,571.74	72.0
Байрны түрээс	23,228,976,000.00	18,584,421,977.44	4,644,554,022.56	80.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,173,035,600.00</b>	<b>3,153,238,049.33</b>	<b>1,019,797,550.67</b>	<b>75.6</b>
Бичиг хэрэг	584,298,500.00	382,908,922.26	201,389,577.74	65.5
Тээвэр, шатахуун	1,691,951,900.00	1,415,821,870.12	276,130,029.88	83.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,359,843,600.00	951,128,549.47	408,715,050.53	69.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,982,700.00	16,141,939.10	77,840,760.90	17.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	442,958,900.00	387,236,768.38	55,722,131.62	87.4
<b>Нормативт зардал</b>	<b>115,006,700.00</b>	<b>30,306,949.25</b>	<b>84,699,750.75</b>	<b>26.4</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,006,700.00	30,306,949.25	84,699,750.75	26.4
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,256,531,100.00</b>	<b>3,108,422,306.05</b>	<b>1,148,108,793.95</b>	<b>73.0</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,867,903,800.00	1,155,885,783.00	712,018,017.00	61.9
Тавилга	195,000,000.00	152,700,296.84	42,299,703.16	78.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,650,000.00	-	24,650,000.00	-
Урсгал засвар	2,168,977,300.00	1,799,836,226.21	369,141,073.79	83.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,132,141,200.00</b>	<b>8,276,429,031.74</b>	<b>6,855,712,168.26</b>	<b>54.7</b>
Гадаад албан томилолт	11,556,322,700.00	6,212,433,122.14	5,343,889,577.86	53.8
Дотоод албан томилолт	10,939,700.00	10,391,285.00	548,415.00	95.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,564,878,800.00	2,053,604,624.60	1,511,274,175.40	57.6
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,636,936,800.00</b>	<b>25,484,496,799.15</b>	<b>13,152,440,000.85</b>	<b>66.0</b>

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,493,592,000.00	13,336,371,288.83	8,157,220,711.17	62.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,646,500.00	2,646,500.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	15,818,391,400.00	11,833,627,500.23	3,984,763,899.77	74.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	793,388,000.00	72,708,248.44	720,679,751.56	9.2
Газрын төлбөр	102,440,200.00	13,971,993.42	88,468,206.58	13.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	426,478,700.00	225,171,268.23	201,307,431.77	52.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,392,307,000.00</b>	<b>3,719,137,641.24</b>	<b>2,673,169,358.76</b>	<b>58.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,130,479,500.00	570,201,816.12	560,277,683.88	50.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,261,827,500.00	3,148,935,825.12	2,112,891,674.88	59.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,087,425,600.00</b>	<b>2,166,960,444.58</b>	<b>2,920,465,155.42</b>	<b>42.6</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,941,277,200.00</b>	<b>1,727,696,439.58</b>	<b>2,213,580,760.42</b>	<b>43.8</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,941,277,200.00	1,727,696,439.58	2,213,580,760.42	43.8
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,146,148,400.00</b>	<b>439,264,005.00</b>	<b>706,884,395.00</b>	<b>38.3</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	407,997,800.00	334,139,625.00	73,858,175.00	81.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	665,440,500.00	48,091,380.00	617,349,120.00	7.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,710,100.00	57,033,000.00	15,677,100.00	78.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>161,290,052,700.00</b>	<b>125,272,336,474.51</b>	<b>36,017,716,225.49</b>	<b>77.7</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>161,290,052,700.00</b>	<b>124,745,545,970.14</b>	<b>36,544,506,729.86</b>	<b>77.3</b>
Улсын төсвөөс санхүүжих	161,290,052,700.00	124,745,545,970.14	36,544,506,729.86	77.3
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>526,790,504.37</b>	<b>(526,790,504.37)</b>	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	526,790,504.37	(526,790,504.37)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,511,626,764.51	(2,511,626,764.51)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	919,400,552.20	(919,400,552.20)	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,402</b>	<b>1,368</b>	<b>34</b>	<b>97.6</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>52</b>	<b>52</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	52	52	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>692</b>	<b>658</b>	<b>34</b>	<b>95.1</b>
Удирдах ажилтан	61	60	1	98.4
Гүйцэтгэх ажилтан	402	376	26	93.5
Үйлчлэх ажилтан	229	222	7	96.9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>15,176,712,421.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>11,850,716,632.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>11,504,698,714.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>827,104,093.29</b>
210101	Үндсэн цалин	-	827,104,093.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>50,226,846.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	20,226,846.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	30,000,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>558,000,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	8,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	7,600,000.00
210304	Байрны түрээс	-	542,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>57,797,906.40</b>
210401	Бичиг хэрэг	-	13,277,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	16,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	12,520,306.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	16,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>5,036,346.00</b>
210502	Хоол, хүнс	-	5,036,346.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>429,416,802.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	76,976,290.00
210602	Тавилга	-	37,339,050.00
210604	Урсгал засвар	-	315,101,462.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>198,013,369.60</b>
210701	Гадаад албан томилолт	-	102,773,499.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	95,239,870.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>1,230,207,915.61</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,197,701,115.61
210803	Даатгалын үйлчилгээ	-	30,500,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	2,006,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>8,148,895,435.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,102,895,435.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	46,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>346,017,918.52</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>346,017,918.52</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	332,845,984.41
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,171,934.11
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,325,995,789.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>3,325,995,789.00</b>
223001	Бусад хөрөнгө	-	1,263,712,895.11
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,062,282,893.89
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>15,176,712,421.52</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>15,176,712,421.52</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,200,222,600.72

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,528,744,609.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	90,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,357,745,211.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 байгууллагын тайлан нэгтгэснээс 3 “Өөрчлөлтгүй”, 1 “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

#### Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар нийт 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өглөө.

#### Албан шаардлага

1. Өмнөх аудитаар төсвийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөж, батлуулж байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна. Засгийн газрын 2022 оны 258 дугаар тогтоолоор Гадаад харилцааны сайдын орлогын доод хязгаарыг 10,000.0 сая төгрөгөөр баталж, Гадаад харилцааны сайд 2023 оны төсвийн саналд төвлөрүүлэх орлогыг 5,000.0 сая төгрөгөөр төлөвлөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, гүйцэтгэлээр нийт 16,033.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана", 27.1.2-т "Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх", 27.1.4-т "жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, ЗГ-ын 2022 оны 258 дугаар тогтоолоор баталсан орлогын доод хязгаарыг баримталж улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төлөвлөөгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

#### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

ГХС-ын нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд ГХЯ, ДБҮЭГ, ДТГ-уудын 87,359.7 сая төгрөгийн газар бүртгэлтэй байна. ДБҮЭГ болон ДТГ-уудын газрын өмчлөлтэй холбоотой маргаантай асуудлыг шуурхай шийдвэрлэх, газрын гэрчилгээ, кадастрын зураггүй газруудыг гэрчилгээжүүлэх, эрх бүхий байгууллагаар баталгаажуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д "газар өмчлөх" гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг", 3.1.3-д "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг" гэж заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Газрын өмчлөлтэй холбоотой шүүхийн маргаантай байгаа газрын асуудлыг шуурхай шийдвэрлэх, газрын гэрчилгээ, кадастрын зураггүй газруудыг гэрчилгээжүүлж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулах.

**2. Харьяа байгууллагуудын зөрчилтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 559.8 сая төгрөгийн 31 зөрчил илэрснээс 5.6 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 35.0 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 559.2 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гадаад харилцааны сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж, нийт зөрчлийг 20.0 хувиар бууруулж ажиллах.

**3. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл 71.5 хувьтай байна. Тайлант онд 5 хөтөлбөрийн 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 арга хэмжээ хэрэгжээгүй, 9 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Гадаад харилцааны бодлого удирдлага хөтөлбөрийн Бүс ба зам санаачилга арга хэмжээ сүүлийн 3 жил төсөвт тусгагдсан боловч хэрэгжээгүй;
- Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрийн гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ арга хэмжээ сүүлийн 3 жил төсөвт тусгагдсан боловч хэрэгжээгүй;
- Гадаад харилцааны бодлого удирдлага хөтөлбөрийн Улс орноо гадаадад сурталчлах арга хэмжээний хүрээнд 2022 онд 4,929.4 сая төгрөг, 2023 онд 4,427.8 сая төгрөг төсөвт тусгагдсан боловч 2022 оны гүйцэтгэл 827.1 сая төгрөг буюу 16.8 хувь, 2023 оны гүйцэтгэл 409.9 сая төгрөг буюу 9.3 хувь;
- Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрийн Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээний хүрээнд 2022 онд 838.1 сая төгрөг, 2023 онд 543.6 сая төгрөг төсөвт тусгагдсан боловч 2022 оны гүйцэтгэл 189.9 сая төгрөг буюу 17.1 хувь, 2023 оны гүйцэтгэл 43.6 сая төгрөг буюу 8.0 хувьтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулж, үндэслэлтэй боловсруулж байх.

Аудитаар нийт 5,186.1 сая төгрөгийн 29 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ГХЯ	1	4.6			1	4.6	1	4.6				
ЮНЕСКО МҮК	13	2,054.5			13	2,054.5	13	2,054.5				
ДБУЭГ ТӨААТҮГ	15	3,127.0			15	3,127.0	15	3,127.0				
<b>Дүн</b>	<b>29</b>	<b>5,186.1</b>	-	-	<b>29</b>	<b>5,186.1</b>	<b>29</b>	<b>5,186.1</b>	-	-	-	-

Аудитаар нийт 414.3 сая төгрөгийн 27 зөрчил илэрснээс, 5.6 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22.3 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 385.4 сая төгрөгийн 15 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ГХЯ	2	2.4					2	2.4				
ЮНЕСКО МҮК	8	138.6	1	0.1	3	1.7	4	136.8				
ДТГ	4	236.0					4	236.0				
ДБУЭГ ТӨААТҮГ	9	36.3	5	5.5	2	20.6	2	10.2				
ГХС	4	-			1	-	3	-				
<b>Дүн</b>	<b>27</b>	<b>414.3</b>	<b>6</b>	<b>5.6</b>	<b>6</b>	<b>22.3</b>	<b>15</b>	<b>385.4</b>	-	-	-	-

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 186.4 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 12.6 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 173.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
ЮНЕСКО МҮК	1	-			1	-		
ДБУЭГ ТӨААТҮГ	1	173.8					1	173.8
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>173.8</b>	-	-	<b>1</b>	-	<b>1</b>	<b>173.8</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
ГХЯ	2	-					2	-
ЮНЕСКО МҮК	2	11.8			2	11.8		
ДБУЭГ ТӨААТҮГ	2	0.8			1	0.8	1	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>12.6</b>	-	-	<b>3</b>	<b>12.6</b>	<b>3</b>	-
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>186.4</b>	-	-	<b>4</b>	<b>12.6</b>	<b>4</b>	<b>173.8</b>